

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр, Пүрэв гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 14
1.	<i>Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай /үргэлжлэл/</i>	6 – 9
2.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай/</i>	9 – 14

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 10 дугаар сарын 16-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 53 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Да.Цогтбаатар;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Э.Батшугар, Б.Дэлгэрсайхан, М.Нарантуяа-Нара, С.Одонтуяа, У.Отгонбаяр, Л.Соронзонболд, Н.Учрал, Б.Энхбаяр.

Нэг.Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай /үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Д.Цогтбаатар: 1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, П.Сайнзориг нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгээс санал болгосон Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх Хуягийн Номингэрэлийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Монгол Улсын Засгийн газраас санал болгосон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Захиргаа, зохион байгуулалтын газрын дарга Норжинлхамын Мөнхбатыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг дараагийн хуралдаанаар үргэлжлүүлэн хэлэлцэхээр тогтов.

Уг асуудлыг 15 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 24 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 17 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 53 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Ирц бүрдсэн тул өнөөдрийн Хууль зүйн байнгын хорооны хурлаа эхлүүлье.

Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгаж мэндчилье.

Ингээд хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Дараах ирцтэйгээр хурал эхэлж байна. Дамдины Цогтбаатар, Халтмаагийн Баттулга, Хүрэлбаатарын Баасанжаргал, Баярмагнайн Баярбаатар, Жудагийн Баярмаа, Одсүрэнгийн Номинчимэг, Бөхчулууны Пүрэвдорж, Даваахүүгийн Пүрэвдаваа, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн ирцтэйгээр хурал нээж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал хоёр байгаа. Өнөөдөр.

Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай.

Хоёр дахь нь, Байнгын хорооны тогтоолын төсөл. Энэ ажлын хэсэг байгуулах асуудлыг өчигдөр хэлэлцэж байгаад бид гүйцээлгүй орхисон байгаа. Үүнийгээ гүйцээж хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал саналаа өгье. Алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай
/үргэлжлэл/

Нэгдүгээр асуудал. Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай.

Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатараас 2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хурлын даргад Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай асуудлыг өргөн мэдүүлсэн.

Уг асуудлыг Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцсэн бөгөөд Байнгын хорооны хурал дээр Улсын Их Хурлын гишүүдээс тухайн асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай гэсэн учраас уг хэлэлцүүлгийг хойшлуулсан.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналын дагуу Байнгын хорооны ажлын албанаас холбогдох материалуудыг бэлтгэн гишүүдэд хүргүүлсэн тул Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэж эхэлье.

Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан өчигдөр асуулт асуусан шүү дээ.

Тэгэхээр одоо бол үргэлжлүүлээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье. Алга байна. /алх цохив/

Х.Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Х.Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Урьд өмнө энэ асуудлыг Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар 2011 онд шийдвэрлэж байсан.

Их Хурал тухайн үед хүлээж авахгүй гээд дараа нь их суудлын хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар шийдвэрлээд ерөнхийдөө агуулгын хувьд гэж хэлж байгаа юм шүү. Үндсэн хууль зөрчсөн гэдэг ийм зохицуулалт гарч байсан. Дүгнэлт гараад ингээд холбогдох хуулиудад өөрчлөлт ороод явж байсан.

Тэгэхээр энэ асуудлыг бид цэцэд өгөхөөр энэ дээр нэг ийм логикийн хувьд л би жоохон гайхаад л байна л даа. Эсвэл бас энэ нь өөрөө улс төрийн юу байгаа болоод хэрвээ бид цэц рүү явуулах нь зүйтэй гэж шийдэх гэж байна уу,

ях гэж байна вэ гэдэг дээр Байнгын хорооны дарга тайлбар өгөх ёстой байх гэж бодож байна.

Яах вэ, Их Хурлын тухай хууль өөрөө Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоож өгөөч ээ гээд цэцэд өгөхөөр Их Хурал өөрөө шийдэх бүрэн эрхийн асуудал байгаа шүү дээ. Гэтэл бид эсвэл шийдэж чадахгүй байна гээд цэц рүү өгөх юм уу, эсвэл энэ нь өөрөө үнэхээр цэцээр хэлэлцүүлэх шалтгаан үндэслэлтэй бөгөөд үүнийг яг улс төр, парламент өөрөө шийдэх, дангаараа шийдэх боломжгүй Үндсэн хуулийн үүднээс нь зайлшгүй тайлбарлуулах шаардлагатай гээд цэц рүү өгөх гэж байна уу гээд яг үүний ялгаа заагийг л би тодруулмаар байна.

Тэгээд үүнийг хэрвээ бид дэмжээд шийдэх юм бол үүний яг холбогдох яг одоогийн байгаа яг С.Ганбаатар гишүүний энэ өгсөн агуулга дээр өгсөн байгаа энэ хүсэлтийн агуулгад зарим нэг үндэслэлүүд дээр жоохон ажиллах хэрэгтэй байна гэж харж байгаа. Тийм.

Д.Цогтбаатар: Х.Баасанжаргал гишүүн яг өөрийн чинь асууж байгаа ийм тодорхойгүй байдал бас байгаа учраас би энд уг нь Их Хурал дээр нарийн судлаад, тэгээд дүгнэлтүүдээ гаргаад өгье өө.

Яг өөрийн чинь ярьж байгаагаар Их Хурал өөрөө засаад явах боломж байгаа бол заавал тийшээ явах шаардлагагүй ээ гээд. Тэгээд энэ тал талаас энэ асуудлууд гараад ирж байгаа учраас энэ дээр чинь бид Үндсэн хуулийн агуулгыг тайлбарлах хүмүүс биш шүү дээ.

Тэгэхээр тал талд өөр өөр энэ байр суурь гараад ирж байгаа болохоор нэгдүгээрт энэ асуудлыг тэр явдаг, хэлэлцдэг газар нь яг экспертмент түвшиндээ ярья гэж нэг үзэж байгаа юм.

Хоёрдугаар асуудал юу гэхээр үнэхээр цаг хугацааны хувьд. Одоо та нар өөрсдөө мэдэж байгаа. Өчигдөр бид энэ асуудлыг жоохон хойшлуулъя гэсэн боловч С.Ганбаатар гишүүний зүгээс хуулийн хугацаагаа бид нарт сануулаад өнөөдөр өглөө бичиг ирүүлсэн.

Ингэнгүүт өчигдөр ерөөсөө энэ асуудлаа маш тодорхой тавиад бид нарт хууль сануулаад, энэ одоо хуулийн хугацаандаа та нар хэлэлцэх ёстой шүү гээд.

Тэгэхээр Хууль зүйн байнгын хороо бол хуулиа л барьж ажиллана. Түүнээс надаас судлахад аягүй их хугацаа хэрэгтэй байна. Тэгсэн чинь энэ хугацаандаа би амжихгүй. Амжихгүй бол одоо амжихгүйгээ үнэнээ хэлээд л тэгээд хуулийг барихаас өөр юугүй болчихож байгаа юм.

Тийм учраас бид өчигдөр боломжийнхоо хэмжээнд өөрсдийнхөө дүгнэлтүүдийг хийгээд гишүүддээ тараагаад л өнөөдөр энэ хурлаа явуулахгүй бол энэ асуудал үүсэж байгаа юм.

Тэгээд өөр гурав дахь шалтгаан нь юу байна гэхээр энэ чинь 2012 онд байсан байх аа. Дүгнэлт гарсан чинь 2012 онд байгаа юм. Тийм. 2011 онд мэдээлэл гаргаад 2012 онд юу энэ асуудлаар дүгнэлт гаргаж байсан юм билээ. Тэгэнгүүт түүнээс хойш Үндсэн хууль чинь өөрөө бас хэд хэдэн өөрчлөгдсөн. 3 өөрчлөгдсөн байж байна шүү дээ.

Тийм учраас үүнийг Үндсэн хуулийн цэц дээрээ очоод өөрсдөө үүгээрээ. Ямар ч гэсэн гишүүн өөрөө тийм хүсэлтэй байгаад бид нарт хууль сануулаад байгаа учраас ингэж байгаа юм.

Түүнээс ахиад үнэнээ л хэлье. Одоо бид бүгдийг мэдэгч биш юм чинь. Бид нарт арай илүү хугацаа байсан бол би танд арай өөр тайлбар өгөх байсан байж болно. Одоо тийм боломж байхгүй байна л даа.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Өчигдөр асуултаа асуугаад, хариултаа авцгаасан байгаа. Ингээд санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд санал хураалтад.

4 санал хураалт явахаар байгаа шүү. Энэ дотор чинь 4 тусдаа асуудал, эрх зүйн асуудал өөрөө хөндөгдөөд босоод ирж байгаа учраас.

1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь заалтын “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь заалтын “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уг гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар

Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

53.8 хувиар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь заалтын “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

53.8 хувиар санал дэмжигдлээ.

4.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь заалтын “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай Улсын Их Хурлын гишүүний саналыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай/

“Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Монгол Улсын Засгийн газраас болон Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгээс санал болгосон төлөөллөөр санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналыг аваагүй болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналыг аваагүй бол санал болгох эрх бүхий байгууллага ажлын хоёр өдрийн дотор өөр хүний нэрийг ажлын хэсэгт оруулахаар Байнгын хороонд ирүүлнэ гэж заасны дагуу 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр дээрх хоёр байгууллагаас ажлын хэсэгт орох төлөөллөө Байнгын хороонд ирүүлсэн байна.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү.

П.Сайнзоригор тасаллаа. О.Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

Үг юу хоёр хамт шүү.

О.Номинчимэг: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Өчигдөр бид Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулалтын хариуцсан ажлын хэсгийг зарим санал хураалтыг хийсэн. Нэлээн маргаантай асуудлууд ч гэсэн гарсан.

Тэгээд ер нь Байнгын хороонд оруулж ирж байгаа асуудлаа харахаар сүүлд нь хурал дууссаны, микрофон хаасны дараа л асуудал мэдлээ л дээ. Санал авахаар явсан бичигт ирсэн хариунууд бүгдээрээ Байнгын хороогоор орохгүй байна.

Тэндээс хэн нэг нь нөлөөлөөд байдаг юм уу, хэн нэгэн нь шийдээд үүнийг нь оруулъя, үүнийг нь оруулахгүй гэдэг юмыг шийдээд байна.

Тэгэхээр Байнгын хороо, Улсын Их Хурал бол өөрөө хамтын шийдвэрийг барьдаг ийм байгууллага. Хэн нэг нь тэндээс нөлөөлөөд үүнийг оруулж болохгүй гэдэг шийдвэрийг Байнгын хорооны өмнөөс гаргаад, нөлөөлөөд тэгээд Байнгын хорооны гишүүдэд зөвхөн энэ хүмүүсийг л эсвэл дэмж, эсвэл дэмжихгүй гэдэг ийм хангалтгүй мэдээлэлтэй оруулж ирмээргүй байна.

Ер нь нэр дэвшүүлэх ажиллагааны ажлын хэсэг байгуулах журмаа ч гэсэн эргэж харах хэрэгтэй байна. Тэр ашиг сонирхлын зөрчлийг нь декларац бөглөдөг. Хэнээс саналыг нь авах вэ гэдгийг тодорхой болгохгүй болбол бид

нарын харж байгаагаар тэр Шүүхийн тухай хууль дээрээ заасан заалтаас давсан журам байгаад байна.

Тэгээд ийм юм асуудал дээр дараа дараагийн юман дээр бас Байнгын хорооны даргыг ч гэсэн анхаараасай, ажлын албыг ч гэсэн анхаараасай гэж бодож байна.

Одоо тэр яриад байгаа уг нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс санал ирсэн юм байна лээ шүү дээ. Яагаад тэрийг нь гишүүдэд танилцуулаагүй юм? Хэн тэрийг нь танилцуулахгүй гэдэг шийдвэрийг нь гаргаад байгаа юм? Тэр хүнд тийм шийдвэр гаргах эрх байгаа юм уу гээд олон олон энэ процессын асуудал гарч байгаа. Энэ бол өөрөө Байнгын хорооны гишүүд өөрсдөө бүрэн мэдээлэл дунд шийдвэр гаргах энэ эрхэд бараг халдаж байна шүү.

Тэгэхээр энэ үүнийг зохион байгуулж байгаа хүний хувьд, ажлын албаны хувьд болон энэ хөндлөнгөөс нөлөөлөөд байгаа хүмүүс үүнийгээ болих хэрэгтэй. Бүгдийг нь оруулж ирээд л альныг нь сонгох сонгохгүйг нь Байнгын хороо өөрөө шийддэг. Гишүүдийнхээ олонхоор. Тийм ээ. Энэ зарчмаа барьж ажиллах хэрэгтэй гэдгийг бас хэлье гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Түүн дээр ингэсэн шүү. Би бол максималный нээлттэй ажиллаж байгаа шүү. Жишээлбэл, үнэхээр одоо нэг хүнийг буцаагаад. Яагаад гэвэл нэг асуудал гараад буцаагаад дараа нь тэрийгээ шалгаж үзээд тэр хүн чинь энэ асуудал нь тийм яригдаж байсан зүйл байхгүй байна гээд тэр хүнийхээ нэрийг би буцаагаад оруулж ирж байх жишээний юмнууд байгаад байна.

Тэгэхээр яг ингээд хүмүүсээс нэр аваад орж ирж байхад бэлтгэх явцад нааш цааш буцаах юмнууд бол нээрээ гарч байна шүү.

Тийм учраас ийм асуудал гарсан. Өөрийн чинь хэлж байгаа нэг юм яг үнэн. Хууль дээр ерөнхий заагаад өгсөн юман дээр журам гаргахдаа яг нэг байгууллагад заасан юм шиг тэр ерөнхий заалтыг нэг байгууллагын нэрийг дурдаад оруулаад ирсэн. Тэр нь яг миний саяын ярьсан асуудал гараад ирэнгүүт өөр сонголтгүй болох тийм эрсдэл гарч байгаа байхгүй юу.

Тийм учраас би бол яг тийм илт хуультайгаа зөрчилдсөн журам байгаа тохиолдолд би хуулиа л барина.

Тийм учраас түүн дээр судалгааны байгууллага тэгэхээр нэгэн дээр нь асуудал хэрэв гарчхаад энэ дээр гарахааргүй байгаа бол би өөр юуг запаас болгоод л авсан тийм асуудал байж байгаа. Түүнээс надад нэг одоо юу гэдэг юм үнэнээ л хэлье. Хүрч ирээд хэн нэг нь азаргалаад нөлөөлнө гэж бол ёстой байхгүй. Тэрний оронд энэ ажлаа би өгчхөөд яваад өгнө. Надад энд ингээд сууж байх ямар ч шаардлага байхгүй.

П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би О.Номинчимэг гишүүнтэй агуулгын хувьд ижилхэн юм хэлэх гээд байгаа юм.

Тэгэхээр Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс бичиг явуулаад аваад нэр ирсэн байна лээ. Энх-Амгалан гээд хүн. Ямар үндэслэлээр энэ Байнгын хороо руу оруулж ирээгүй вэ гэдгийг яг одоо тайлбарлах нь зөв байх.

Энэ 2021 оны 3 сарын 10-ны өдөр Хууль зүйн байнгын хорооноос баталсан 06 дугаар тогтоол. Энэ дээр ингээд заасан.

Тэгэхээр энэ хууль зөрчиж байвал бид хэд хүчингүй болгомоор байгаа юм. Уг нь үүнийг бас давхар оруулж ирээд дарга аа, уг нь бас санаачлаад. Энэ дээр бүр ингээд энэ 11 төлөөлөл дээр бүр заасан байгаа юм л даа. 6.2.9 дээр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн санал болгосон нэг төлөөлөл гээд. Дарга аа.

Тэгэхээр үүнийг уг нь хүчингүй болгомоор байгаа юм. Одоо яг үүнийгээ ажлын хэсгийг цаашдаа цаашдаа хууль ёсны байна гэж үзвэл. Энэ дээр чинь маргаан гарах гээд байгаа байхгүй юу.

Хоёрдугаарт, ер нь зүгээр бид хэд нөгөө хууль тогтоомжийн хуулиар маргадаг юм энэ дээр гарч ирж байгаа юм. Нөгөө эрх олгосон заалтыг шүүх болон цэцэд хянагддаггүй Байнгын хороонд шилжүүлж болохгүй буюу тухайн нэг байгууллагын шууд дотоод нэгж рүү шилжүүлээд байгаа нь буруу байгаа юм. Энэ журам магадгүй яг агуулгынхаа хувьд Улсын Их Хурлаар батлагдаад, эсвэл Үндсэн хуулийн цэц, эсвэл тодорхой Засгийн газрын гүйцэтгэх эрх мэдэлд хянагдаад цэц юм уу, Захиргааны шүүхээр л явах ёстой байгаа байхгүй юу. Гэтэл ингээд бид хэд ингээд дунд нь завсрын институцүүдэд ийм эрх шилжүүлээд энэ олон зүйлүүд ингээд хяналтгүй явж байгаа юм.

Хоёрдугаарт, Цогоо даргыг маань одоо нэг зүйлийг хүлээж авчхаасай гэж бодоод байгаа юм. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулахдаа Улсын дээд шүүхийн судалгааны академиас нэг төлөөлөл орж байгаа нь өөрөө туйлын буруу. Шүүгч бус гишүүдийг шүүгч нарын нөлөөгүйгээр сонгож 5, 5 гишүүн бүрдүүлэх гэж байгаа болохоос бид Улсын дээд шүүхийн судалгаа хийдэг, Улсын дээд шүүхийн шүүгч нарын чиглэлээр ажилладаг ийм институцээс энэ ажлын хэсгийг бүрдүүлж байгаа нь буруу байгаа юм. Үүнийг уг нь залруулах хэрэгтэй байна. Заавал Хууль зүйн үндэсний хүрээлэн ч гэсэн гэж байгаа юм биш. Үүнийгээ уг нь нэг зарчмаараа шийдмээр л байгаа юм. Тэгээд энэ ажил уг нь зөв л явмаар байгаа юм л даа.

Тэгээд хуулийн маань баталсан концепц дээр байхгүй юу. Шүүгч бус гишүүдийг арай шүүхийн оролцоогүй буюу шүүхийн хамааралгүйгээр сонгодог. Шүүгч нар маань өөрсдөө нийт шүүгчдийн хуралдаанаасаа шат шатын шүүгчдийн 5 төлөөлөл гаргаж ирж байгаа шүү дээ. Улсын дээд шүүхээс 1, давахаас 2, анхан шатаас 2 байхгүй юу. Тэгээд ийм байдалтай байгаад байгаа юм.

Тэгэхээр яах вэ, зүгээр 11-ээс 1 хүний санал боловч санал тэнцсэн тохиолдолд магадгүй тэр Шүүхийн судалгааны академийн хүн буюу шүүгчдийн төлөөлөл шууд бусаараа шүү. Шийдэх гээд байгаа байхгүй юу. Асуудлыг.

Тэгэхээр уг нь энэ зарчмаа бодоод энэ асуудлыг уг нь залруулаад л явмаар байгаа юм. Тэгээд би түрүүн гишүүддээ бас горимын санал гаргаж байсан. Өмнө нь хурааж байсан тэр Дөлгөөн гэдэг залуу байсан уу, бүсгүй ч байсан уу. Би сайн мэдэхгүй байна. Үүнийг хураасан саналыг хүчингүй болгоод дахиад судалгааны институцээсээ Цогоо дарга хаашаа байдаг юм явуулаад нэр авмаар байна л гэдэг зүйл байна.

Тэгээд болдог бол дахиад энэ дээр горимын санал гаргаад хураалгаж өгөөч ээ гэж хүсэлттэй байна.

Д.Цогтбаатар: П.Сайнзориг гишүүний саналтай би хэд хэдэн зүйл дээр санал нэгдэж байгаа. Юу гэвэл үнэхээр энэ журам байна шүү дээ хууль дээрээ өргөн заасан байхад яг Хууль зүйн үндэсний хүрээлэн гээд журмаараа бүр тодорхой. Уг нь журам нь юу зааж өгөх ёстой вэ гэхээр энд шалгаруулах хүний ажилласан он жил, тэр мэргэжлээрээ ажилласан энэ шалгуурууд байх ёстой байтал энд яг байгууллагад зориулаад заагаад өгсөн байж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хууль, журам хоёр зөрчигдөхөд би түрүүн Х.Баасанжаргал гишүүнд хэлсэн. Би хуулиа л барьж байгаа юм.

П.Сайнзориг гишүүний би саналыг өчигдөр дэмжээд, горимын саналаар санал хураалгангуут гишүүд дэмжээгүй. Би таны саналыг өөрөө дэмжиж өгсөн. Тэгээд дэмжээгүй юмыг одоо хоёулаа гишүүдийн эрхэнд халдаад би хэрэггүй гэж бодож байгаа.

Үүнийгээ тэгэхээр түүгээр нь үргэлжлүүлье. Харин цаашдаа ер нь би Байнгын хорооныхоо юмнуудад ч хэлмээр байгаа юм. Энэ журмыг нь бид эргэж хараад ёстой засах юман дээрээ ажиллахгүй бол болохгүй байна гэж бодож байгаа юм. Ийм байна.

Тэгээд тэгвэл гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа. Тэгээд санал хураалтдаа ороод явъя.

Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгээс санал болгосон Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх Хуягийн Номингэрэлийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтдаа бэлдэцгээе. Санал хураалтыг түр цуцалъя. Санал хураалтдаа бэлдье. Санал хураалт. /алх цохив/

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Засгийн газраас санал болгосон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Захиргаа, зохион байгуулалтын газрын дарга Норжинлхамын Мөнхбатыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Энэ дэмжигдсэнгүй уналаа. Тийм. Зөв зөв. П.Сайнзориг гишүүн. Одоо яая гэх вэ.

Үүнийг одоо тэгэхээр чинь бас буцаагаад л дахиад л хоёр хоногийн дотор оруулж ирэхгүй л бол болохгүй боллоо шүү дээ. Тэгвэл энэ хүн дэмжигдсэнгүй. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг.

Энэ тогтоолыг маргааш дахиж хуралдаад яах юм байна шүү дээ. Тийм ээ. Тэгэхгүй бол болохгүй юм байна.

Тэгвэл хуралдааныг үүгээр би түр завсарлуулъя. Тийм. Завсарлуулаад тэгээд маргааш. Тэгэхгүй бол одоо тэртээ тэргүй санал хүрэхгүй. Тогтоол батлагдахгүй болж байна. Тийм.

Тэгвэл ингээд өнөөдөр бид хэлэлцэх асуудлаа хэлэлцлээ. Ингээд энэ асуудлыг дараагийн хуралдаан руу бид шилжүүлж байна. Ингээд өнөөдрийн хуралдааныг хаалаа. /алх цохив/

Хуралдаан 24 минут үргэлжилж, 15 цаг 17 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

ЦАЛТАН-ОД